> хил хамгаалах байгууллагын хөгжил, стратеги;
> хил хамгаалах тактик, технологи;

Инновацийг нэвтрүүлж хэрэгжүүлэхэд дараах асуудалд анхаарах нь зүйтэй гэж үзэж байна.

1. Инноваци нь хил хамгаалах байгууллагын стратегийн бодлого, төлөвлөлтийн салшгүй хэсэг байх ёстой.
2. Мэдээллийн урсгалыг инновацид нөлөөлдөг, засаглалын инновацийг эрс сайжруулах гол хүчин зүйлийн нэг гэж үздэг тул харилцан ажиллагаатай байгууллагын хооронд мэдээлэл солилцох, бодлого боловсруулах, хэрэгжүүлэхдээ нээлттэй илтод байх соёлыг нэвтрүүлэх.
3. Инновацийг нэвтрүүлэх, түгээх үйл ажиллагааны үнэт зүйл нь урт хугацаанд болдог тул байгууллага өөрөө инновацийг хүлээн зөвшөөрөх, амжилтийг онцлон тэмдэглэх, сайн туршилтийг түгээх механизмыг хэрэгжүүлдэг байх.

*ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын*
*академийн суралцагч,*
*дэд хурандаа Т.Нурлан*

## ХИЛ ХАМГААЛАЛТЫГ УДИРДАН, ЗОХИОН БАЙГУУЛАХ, ШИЙДВЭР ГАРГАХАД ЭРҮҮГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫГ ХАРГАЛЗАХ НЬ

***Хураангуй.*** *Энэхүү илтгэлээр баруун бүсийн БНХАУ-тай хиллэсэн хилийн хэсгийн нөхцөл байдал, түүнд хиисэн дүн шинжилгээ хийж цаашид авах арга хэмжээ, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга замыг тодорхойлохыг зорьсон болно.*

***Түлхүүр үг.*** *Хил хамгаалах байгууллага, хилийн зөрчил, хилийн нөхцөл байдал, эрүүгийн нөхцөл байдал.*

Манай улсад эрүүгийн нөхцөл байдал хүнд, тэр тусмаа ноцтой гэмт хэргийн эзлэх хувь өндөр, нарийн, далд аргаар бодож төлөвлөсөн, зэвсэглэсэн харгис хэрцгий шинжийг агуулах болсон бөгөөд хил дээр, хил орчимд гарч буй хилийн зөрчилтэй холбоотой хэрэг ч эдгээр шинжийг агуулах болсон төдийгүй терррoризмыг нөхцөлдүүлэгч хүчин зүйл болох хар тамхи, сум, галт хэрэгсэлийн наймаа, хууль бус цагаачлал, дүрвэгсэд, хүний наймаа, хил орчмын ард иргэдийн амьдралын доройтол зэрэг нь улсын хилтэй салшгүй холбогдож, улсын хил давуулан оруулах, гаргах, хилээр дамжуулах хэрэг, зөрчил байсаар байна. Мөн хоёр хөрш маань хар тамхи, мансууруулах бодис хэрэглэх, борлуулах, үйлдвэрлэх, зохион байгуулалтай гэмт хэргийн бүлэглэл хүчирхэгжсэн, дэлхийн гэмт хэргийн ертөнцөд нөлөөллөө тогтоосон, далд эдийн засаг, хээл хахууль нийгмийн

бүх давхаргыг хамарсан, террорист ажиллагаа байнга гардаг зэрэг нийгмийн онц аюултай үзүүлэлтээрээ дэлхийд тэргүүлдэг улс орны тоонд багтаж байна.

Сүүлийн жилүүдэд улсын хил орчмын нутагт илрэх хэлбэр, давтамж нь нэмэгдэх болсон хил хамгаалалтад хил орчмын нутаг дэвсгэрийн эрүүгийн гэмт хэргийн нөхцөл байдлын нөлөөлөл олон хэлбэрээр илэрч байна. Үүнд: Дүрвэгсэд, хууль бус иагаачлал, хил дамнасан хууль бус наймаа. байгалийн нөөц баялгын төлөөх тэмцэл, малын хулгай. хил дамнасан зохион байгуулалтай гэмт хэрэг багтаж байна. Улсын хил, хилийн бүс зурваст үүсэх эрүүгийн гэмт хэргийн шинжийг агуулсан байнга давтагдсан хилийн зөрчил нь:

> Монгол Улсын хилийг хувийн сонирхол, ашиг хонжооны үүднээс ашиглаж, хилээр хориотой эд барааг хууль бусаар гаргах, оруулах;

> Хөрш орны иргэдтэй урьдчилан тохиролцож хууль бус наймаа хийх;

> Тухайн хэсэг, чиглэл, хязгаар нутагт тогтворгүй байдлыг бий болгох;

> Хил зөрчин ирж, хил орчмын нутагт дэвсгэрт зэвсэгтэй ба зэвсэггүйгээр дээрэм тонуул хийх, иргэдийн эд хөрөнгө, малыг хулгайлах, дээрэмдэх халуун, хүйтэн зэвсэг хэрэглэх зэргээр иргэдэд айдас түгшүүр төрүүлэх;

> Орон нутгийн иргэдтэй хамтран өмч хөрөнгө, амь зуулга болсон малыг хуйвалдан хулгайлснаар амьдралын доройтол ядууралд хүргэх, хил орчимд нутаглаж, амьдрах бололцоогүй болж улмаар хязгаар нутаг эзэнгүйдэх, засаг төр, хууль хяналтын байгууллагад итгэх итгэлийг алдагдуулахад хүргэж байна.

Түүнчлэн дарга, захирагч хамгаалалтыг удирдахад өөрсдийн олон жилийн туршлага, мэдрэмжинд тулгуурлах нь үеэ өнгөрөөсөн бөгөөд хил хамгаалалтыг шинжлэх ухааны үндсэн дээр удирдан, зохион байгуулах шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Өнөө үед хил хамгаалах байгууллагад шинэ хүчирхэг, орчин үеийн техник хэрэгсэл нэвтэрч, хилийн зөрчлийн арга хэлбэр өөрчлөгдөж байгаа нь сайшаалтай юм.

Манай улсын тухайд хил даван мал хулгайлах, дээрэмдэх, хориглосон барааг улсын хилээр нэвтрүүлэх, хилийн манаа, ард иргэдийн эсрэг зэвсэг хэрэглэх, амь насанд нь халдах, ан агнах, байгалийн баялаг ашиглах зэргээр хил орчмын нутаг дэвсгэр дэх эрүүгийн нөхцөл байдал хүнд байдаг нь хил хамгаалалтад ихээхэн нөлөө үзүүлж байна. Уулархаг бүс хойд талаараа ОХУ-ын Уулын Алтайн Кош-Агач, Улаган, Тувагийн

Бүгд Найрамдах Улсын Монгөн тайга хошууны Мукур-Аксы, Овөр хошуутай 675.8 км хэсгээр, баруун өмнөд хилээрээ БНХАУ-ын Шинжаны өөртөө засах орны Алтай, Цонж, Хами аймагтай нийт 1017.9 км хэсгээр хиллэн Монгол Улсын хилийн хэсгийн 20.6 хувийг эзэлж байна.

Тус бүс нутагт Баян-Өлгий, Ховд, Увс аймаг дахь хилийн отрядын хариуцсан хэсэг; Баян-Өлгий аймгийн Ногооннуур, Цэнгэл, Улаанхус, Сагсай, Алтай, Дэлүүн, Булган, Увс аймгийн Бөхмөрөн, Сагил, Давст, Тэс, Зүүнговь, Баруунтуруун, Ховд аймгийн Булган, Үенч, Алтай, Говь-Алтай аймгийн Тонхил, Бугат, Алтай, зэрэг 4 аймгийн 19 сумын нутаг дэвсгэр дэх хилийн бүс зурвас, хилийн отряд, застав, харуулын хариуцсан 1985.5 км хэсэг буюу улсын хилийн 24.0 хувь хамрагдана.

Уулын бүсийн Монгол-Хятадын хилд Монголын талаас алт, зэсийн баяжмал, тарваганы арьс, ховср ан амьтаны эд эрхтэн, чоно, түүхий эд, ноолуур, чулуужсан мод хууль бусаар хил давуулах зэрэг наймааны шинжтэй гэмт хэрэг, Хятадын талаас мал хулгайлах, спирт, хил дээр солилцох, хар тамхи, зэрэг хилийн зөрчил гэмт хэргийн зохион байгуулалтад орсон байна.

Улсын хилийг ашиг орлого олох бохир бизнесийн талбар болгохоор гэмт хэргийн бүлэглэлүүд хил орчмын нутаг дэвсгэрт суурьиих, байрших, төлөөний этгээдийг нутгийн иргэдээс бүрдүүлэх, хил, хяналт, хүчний байгууллагын албан хаагчдыг өөрсдийн гар хөл болгох ажиллагааг идэвхжүүлсээр байгаа нь нууц биш болсон. Уулын бүсийн Монгол-Хятадын хилд сүүлийн 5 жилд гарч буй хилийн зөрчлийн хэлбэрийг судлан дүгнэлт хийж үзвэл дараах онцлог байдал илэрч байна.

*Нэг.* Монгол-Хятадын хилд гарсан зөрчил нь ахуйн шинж, эдийн засгийн агуулга зорилготой, хилийн зөрчил давамгайлж байсан бол сүүлийн үед гарсан хилийн зөрчил нь эрүүгийн шинж чанартай, цагаачлалын зорилготой манай улсаар дамжин гуравдагч оронд амьдрахыг эрмэлзэгч гадаадын иргэдийн зөрчил эзэлж байгаа явдал юм.

*Хоёр.* Өмнөд хил дээр сүүлийн жилүүдэд гарч буй эрүүгийн шинж чанартай хилийн зөрчлийг өмнөх зөрчилтэй харьцуулбал маш нарийн зохион байгуулалттай болж байгаа нь онцлог юм.

*Гурав.* Гэмт этгээдийн улсын хил зөрчих арга өөрчлөгдөж, хилийн зөрчил нарийн зохион байгуулалттай болж байгаатай уялдан хилийн зөрчлийн үргэлжлэх хугацаа, хурд маневр, өндөржиж илрүүлэлтэд хүндрэлтэй байдал үүсч байна.

Гэмт этгээдүүд өндөр хурдтай машин техник, холбоо, дуран хараны хэрэгсэл ашиглах, уулын бүсийн газар орон, улирал, цаг уур, агаарын байдлыг ашиглан зөрчил гаргаж байна.

Байгаль цаг улирлын нөхцөл байдал нь хилийн аюулгүй байдлыг хангах, хил хамгаалалтыг зохион байгуулан явуулах, улсын хилийн болон хил орчмын дэглэм зөрчигчдийн үйлдлийг таслан зогсооход эерэг болон сөрөг хүчин зүйлийг үзүүлж байдаг.

- Орон нутгийн харилцан ажиллагаатай байгууллагатай хамтран ажиллах шаардлагатай үед түүний хүч хэрэгслийг авах боломж хязгаарлагдмал;

- Хүч хэрэгслийг шилжүүлэн бүлэглэх, маневарлах, цагийн байдал үүссэн үед эрэл зохион байгуулан явуулахад хүндрэлтэй.

*Дөрөв.* Хэдийгээр хилийн зөрчлийн илрүүлэлт, шийдвэрлэлт ойролцоо түвшинд байгаа боловч улсын хил зөрчсөн гэмт этгээдийн гэмт үйлдлийг шүүхээс хэрэгсэхгүй болгох, торгох төдийгээр гэмт этгээдэд ял завшуулж байгаа нь хилийн зөрчлийг таслан зогсоох, бууруулах ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж байна.

Гол анхаарлаа хандуулж, хөндөн тавьж байгаа асуудал бол улсын хил хамгаалах шийдвэр гаргахад эерэг тал /хил зөрчигч/ тэр тусмаа эсрэг талын эрүүгийн нөхцөл байдлыг харгалзах, тооцох, урьдчилан харах явдал билээ. Ер нь аливаа хууль бус ажиллагаа, хил орчмын нутагт үүсэж байгаа эрүүгийн гэмт хэрэг нь бусад гэмт хэргээс ялгагдах хэд хэдэн онцлогтой. Үүнд:

- Объект нь Монгол Улсын хилийн халдашгүй дархан байдал
- Субъектив талаасаа шууд санаатай, шунахай сэдэлтэй
- Субъект нь хөрөнгө мөнгөтэй, эсвэл эрх мэдэл бүхий өндөр албан тушаалтан байх нь цөөнгүй
- Богино хугацаанд их хэмжээний ашиг олдог эсвэл алддаг учраас нарийн зохион байгуулалт зайлшгүй шаардаж, хээл хахууль, авилгал, хүчирхийлэл зэрэг эрүүгийн гэмт хэргийн хамгийн хүнд хэлбэрийг сүүдэр мэт дагуулдаг нь зохион байгуулалтай гэмт хэрэг улам газар авах нөхцөл болдог аюултай.

Хил залгаа болон өөрийн улсын хил орчмын нутаг дэвсгэрийн эрүүгийн нөхцөл байдал, гарч болзошгүй хилийн зөрчлийн хэлбэр, арга тэр тусмаа эрүүгийн хэргийн сэдэл, шинжийг нь улсын хил хамгаалах шийдвэр гаргах, цагийн байдлыг үнэлэх, эерэг талыг үнэлэх, өөрийн хүч хэрэгсэлийг үнэлэхэд харгалзах төдийгүй цагийн байдлыг үнэлэх нэг элемент болгон баталгаажуулах шаардлагатай байна.